

“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

20 оны 8 сарын 30

Дугаар

Улаанбаатар хот

“Евразия капитал холдинг ҮЦК” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 8-р сарын 30 өдөр 10 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Худалдааны гудамж, Дельта төв 5-р давхар, 502 тоот өрөөнд өрөөнд эхлэв.

Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч нийт ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Энэхүү хуралд компанийн хувьцаа эзэмшигчид болох “Мезза Файнэншл Групп” ХХК, “Омега Инвест” ХХК, “Вистекс Глобал Инвест” ХХК нар оролцсон бөгөөд нийт 2 197 018 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 2 270 892 ширхэг энгийн хувьцааны 96.7% болж хурал хүчин төгөлдөр эхлэв.

Хурлын дарга Г.Халиунаа:

- Хурлыг онлайнаар нээж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:
 1. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах
 2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах
 3. Өрийг хувьцаагаар солих
 4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
 5. Шаардах эрх хэрэгжүүлэх тухай
 6. Бусад.

Хурлаар, хэлэлцэх асуудлаа нэг бүрчлэн авч хэлэлцээд тухай бүрд нь асууж тодруулах зүйлээ асууя гэсэн саналтай байна. Та бүхэн юу гэж бодож байна?

Хуралд оролцогчид:

- Зөвшөөрч байна.

Хурлын дарга Г.Халиунаа:

- Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах тухай компанийн хувьцаа эзэмшигч “Мезза Файнэншл Групп” ХХК-ийн захирал Камолиддин Талипов танилцуулна.

Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Компани нь нээлттэй хувьцаат компанийн хувьд үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулахад Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах шаардлагатай байгаа тул хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг арван тэрбум хүртэл төгрөгөөр нэмэгдүүлэх саналтай байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхдээ олон нийтэд болон хаалттай хүрээнд, стратегийн хөрөнгө оруулагчдад нэр заан эзэмшүүлэхээр арван тэрбум хүртэл төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа

компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулъя. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох нь зөв гэж үзэж байна. Нэмж гаргах хувьцааг худалдан авах хөрөнгө оруулагчидтай бид харилцан тохролцсон байгаа.

Бид нэмэлт хувьцаа гаргаснаар хувьцааныхаа төвлөрлийг бууруулах мөн үйл ажиллагаагаа хэвийн явуулах ач холбогдолтой. Компанийн хувьцааны тоо ширхэг нэмэгдэж байгаа нь мөн үйл ажиллагааны чиглэлд Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг нэмж оруулж байгаа нь компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл болж дүрмийн шинэчилсэн найруулгыг бэлтгэн та бүхэнд танилцуулж байна. Дараагийн асуудал болох өрийг хувьцаагаар солих асуудал байгаа. Манай компани бусдад өгөх өр төлбөр ихтэй байгаа. Өрийг хувьцаагаар солих хүсэлттэй байгаа хувьцаа эзэмшигчидтэй тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсны дараа шийдвэрлэх эрхийг ТУЗ-д өгөх саналтай байна.

Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчид:

- Зөвшөөрч байна.

“Омега Инвест” ХХК компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Саидаброр Рустамходжаев:

Бидний хэлэлцэх дараагийн асуудал бол ТУЗ-ийн гишүүдийн сонгох тухай байгаа. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгох саналтай байна.

1. ТЭМҮҮЛИН Энхмөнх
2. САРАНЧИМЭГ Энхээ
3. МАШБАТ Дашзэгвэ
4. САИДАБРОР Рустамходжаев
5. ХАЛИУНАА Ганчимэг
6. САЙНБОЛОР Мягмар

Харин дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгуулахаар санал оруулж байна.

1. БЭХБАТ Содном
2. БАЙЛИХҮҮ Дамбачүлтэм
3. НОМИНГЭРЭЛ Лхагвасүрэн

Та бүхний өмнө нэр дэвшигчдын танилцуулага, анкетыг тараасан байгаа. Асуух зүйл байвал асуугаарай, мөн та бүхнээс ТУЗ-ийн гишүүнд санал болгох хүн байвал нэр дэвшүүлж болно шүү.

Та бүхэнд асууж тодруулах зүйл байвал санаа зоволтгүй асууж болно.

Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчид:

- Зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч “Мезза Файнэншл Групп” ХХК түүнийг төлөөлж Камолтидин Талипов:

Компанийн дүрэмд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан 2022 оны 8-р сарын 30 өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй гэсэн шийдвэр гаргах нь зөв байх гэж үзэж байна. Энэ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах ач холбогдолтой гэж үзэж байна.

Нэмж хувьцаа гаргах зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрсний дараа шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг худалдаж авах үнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоосон үнээр эргүүлэн худалдан авах нь зөв байх. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор арван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргахтай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэх саналтай байна.

Мөн бусад гэх асуудлын хүрээнд Компани үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэх зорилгоор мэдээлэлийн технологи, маркетинг зэрэг салбарт үйл ажиллагаа явуулах “Евразиа дижитал венчерс” ХХК болон “Евразиа секьюритис” ХХК гэх охин компаниудыг үүсгэн байгуулах саналтай байна. Уг охин компаниудын 100 хувийн хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагчаар “Евразиа Капитал Холдинг ҮЦК” ХК байх юм.

Хувьцаа эзэмшигчид:

- Асуух зүйл байхгүй. Дэмжиж байна. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийг шинээр томилогдох ТУЗ болон ТУЗ-ийн даргад үүрэг болгох саналтай байна.

Хурлын дарга Г.Халиунаа:

Хувьцаа эзэмшигчдийн санал хүсэлтийн дараа саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсний дараа хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

“Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна” хэмээн Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Х.Мөнгөнцэцэг танилцууллаа.

“Евразиа капитал холдинг ҮЦК” ХК-ийн 2022 оны 8 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлав.
2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргахыг зөвшөөрөв.
3. Өрийг хувьцаагаар солих асуудлыг зөвшөөрөв.
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгов.
5. Шаардах эрх хэрэгжүүлэх үүргийг ТУЗ-д өгөв.
6. Бусад асуудлын хүрээнд “Евразиа дижитал венчерс” ХХК болон “Евразиа секьюритис” ХХК гэх охин компаниудыг үүсгэн байгуулахыг зөвшөөрөв.

Хурлын дарга Г.Халиунаа хурлыг хаав.

Хурал: 12 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

Хянасан:

Хурлын дарга:

Г.Халиунаа

